



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2017 оны 4 дугаар тогтоолын
1 дүгээр хавсралт

СУМЫН ИТХ-ЫН БОЛОН БАГИЙН ИНХ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ, МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ ЖУРАМ

Нэг. Зорилго:

1.1. Сумын ИТХ-ын болон багийн ИНХ-ын үйл ажиллагаанд үнэлгээ хийж мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх журмын үндсэн зорилго нь сумын ИТХ болон багийн ИНХ-ын үйл ажиллагааны бодлогын зорилтын хэрэгжилтийн явц, үр дүнг шинжлэн үнэлсэнээр мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, дэмжлэг үзүүлэхэд оршино.

1.2. Дээрх үндсэн зорилгыг хангахын тулд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ.
Үүнд:

1.2.1. Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааны үнэлгээг бэхжүүлж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах ажлыг сайжруулах

1.2.2. Орон нутаг дахь нутгийн өөрөө удирдах байгууллагуудын үйл ажиллагааны үнэлгээний мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангах.

Хоёр. Үйл ажиллагааны үнэлгээний зарчим, хамрах хүрээ.

А. Үнэлгээний зарчим

1. Шударга, хөндлөнгийн нөлөөнөөс хараат бус байх
2. Үнэлгээ хийгдэж буй байгууллагын үйл ажиллагаа, тэдгээрээс гаргасан тайлан, дүгнэлт ил тод байх
3. Үнэлгээний тоо баримт судалгаа, мэдээлэлд үндэслэсэн, тухайн бодлого, хөтөлбөр, төслийн үр дүн, үр ашиг, үр нөлөөг тодорхойлсон, хэмжигдэхүйц, нотлогдохуйц байх.
4. Үнэлгээг тодорхой үе шаттай хийх.
5. Үнэлгээнд иргэн, иргэний нийгмийн байгууллага, хамтран ажиллагч талуудын санал дүгнэлтийг авсан байх.

Б. Үнэлгээнд тавигдах шаардлага

1. Үнэлгээний ажлын хэсгийг аймгийн ИТХ-ын даргын захирамж болон нарийн бичгийн даргын тушаалаар томилж удирдамжийг батална.

2. Ажлын хэсэг тухайн байгууллагад хийсэн үнэлгээний дүнг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулан иргэдэд мэдээлнэ.

Тэргүүлэгчдийн хуралдаанд үнэлгээний дүнг танилцуулж тэмдэглэл гаргах ба тус тэмдэглэлд хуралдаанд оролцсон Тэргүүлэгчдийн ирц, оролцогчдын нэр, хэлэлцэх асуудлын агуулга, хуралдааны явц болон шийдвэрийг тусган, хуралдаанд оролцсон гишүүдийн гарын үсгийг зуруулж баталгаажуулна.

3. Үнэлгээ хийхэд ашигласан мэдээ, баримт нь үнэн зөв байх бөгөөд түүний үнэн зөв, эсэх асуудлыг ажил хариуцсан мэдээлэл өгсөн албан тушаалтан хариуцаж, хариуцлагаа бүрэн хүлээнэ.

5. Үнэлгээний эцсийн дүнг гаргахдаа бодит үр дүн, төлөвлөсөн зорилтын өсөлт бууралт, тасалдлын шалтгааныг нарийвчлан тооцно.

6. Аймгийн ИТХ-аас томилогдсон ажлын хэсэг сумын ИТХ, багийн ИНХ-ын үйл ажиллагаанд хийсэн үнэлгээний дүнг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулна.

7. Сумын ИТХ тухайн тайлангийн жилийн ажлын дүнг тус үнэлгээний үзүүлэлт бүрээр гаргаж үнэлэн, бичвэр тайлангийн хамт аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын албанд 1 дүгээр сарын 20-ний дотор ирүүлнэ.

Гурав. Дүгнэх аргачлал

3.1. Тогтоол, шийдвэр, хөтөлбөрүүдийн холбогдох заалт, зорилт нэг бүрийн гүйцэтгэлийг өссөн дүнгээр гаргаж тухайн зорилтын шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшинтэй харьцуулж хувиар илэрхийлэн дундаж оноогоор дүгнэнэ.

3.2. Зорилтын биелэлтийг дор дурьдсан томъёогоор бодно.

$ЗБ = \frac{Г}{3}$ Энэ үнэлгээг хувиар илэрхийлэх бол $ЗБ = \frac{Г}{3} * 100$ гэж тооцно.

ЗБ-зорилтын биелэлт

Г-гүйцэтгэл

З-зорилт буюу хүрэх түвшин

3.3. Тоогоор илэрхийлж үнэлэх боломжгүй зорилтын шалгуур үзүүлэлтийн биелэлтийн хувийг тодорхойлоход дараах зарчмыг баримтална.

3.4. Тухайн заалтаар тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, энэ талаар холбогдох шийдвэр, үр дүн гарч тогтворжсон бол 100,0 хувь

3.5.Тухай заалтаар тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа бол 90,0 хувь (80%-100% хүртэл)

3.6. Тухайн заалтаар тавьсан зорилгодоо хүрэхийн тулд өөрсдөөс хамаарах бүх шийдвэрийг гарган, санхүүжилтийн асуудал шийдвэрлэгдсэн, шийдвэр гаргагч дээд байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа бол 70% (60%-80% хүртэл)

3.7. Бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн бол хийгдэж байгаа ажлын түвшинг харгалзан 50% (40%-60% хүртэл)

3.8. Тухайн заалтад тусгагдсан асуудлыг шийдвэрлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа бол хийгдэж байгаа ажлын түвшинг харгалзан 30% (20%-40% хүртэл)

3.9. Арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон арга хэмжээг авч эхэлж байгаа бол ажлын түвшинг харгалзан 10% (0%-20% хүртэл)-ийн биелэлттэй байна гэж үзнэ.

3.10. Ямар ч ажил зохион байгуулаагүй бол 0 үнэлгээ өгнө.

4. Үнэлгээний нэгдсэн дүн гаргах:

4.1. Тухайн үндсэн үзүүлэлтийн үнэлгээг гаргахдаа түүний холбогдох үзүүлэлт бүрийн үнэлгээг тодорхойлж нийлбэрийг үзүүлэлтийн тоонд хувааж дундаж үнэлгээг тодорхойлно. Тус үндсэн үзүүлэлтийн дундаж үнэлгээний дүнгээр тухайн үзүүлэлтийн авбал зохих оноог үржүүлэн үндсэн үзүүлэлтийн бодит үнэлгээг тодорхойлно. Журмын хавсралтаар баталсан үндсэн 4 үзүүлэлтийн бодит үнэлгээний нийлбэр дүнгээр тухайн байгууллагын үйл ажиллагааны ерөнхий үнэлгээг гаргана.

Үйл ажиллагааны биелэлтийн ерөнхий оноо дараахь үнэлгээг илэрхийлнэ.
Үүнд:

- 1/. 90,00 хувиас дээш "А" үнэлгээ / Үйл ажиллагаа бүрэн тогтмолжсон/
- 2/. 80,00-90,00 хувь хүртэл "В" үнэлгээ /Үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа/
- 3/. 70,00-80,00 хувь хүртэл "С" үнэлгээ /Үйл ажиллагааны зарим асуудлуудыг сайжруулах шаардлагатай/
- 4/. 60,00-70,00 хувь хүртэл "Д" үнэлгээ /Үйл ажиллагаагаа жигд сайжруулах шаардлагатай/
- 5/. 60,00 хувиас доош "F" үнэлгээ өгнө. /Үйл ажиллагаа хангалтгүй

хэрэгжиж байна/

5. Үнэлгээ хийсэн ажлын хэсэг байгууллагын үйл ажиллагааны үзүүлэлт бүрийн үнэлгээний дүнг шинжилж ололт, амжилтыг тодорхойлж цаашид анхаарах асуудлаар мэргэжил арга зүйн зөвлөмжийг бичнэ.

Зургаа. Үнэлгээний урамшуулал

6.1. Үйл ажиллагааны ерөнхий үнэлгээний дүнгээр хамгийн өндөр оноо авсан 3 хүртэл сумын ИТХ-ыг шалгаруулан дараах шагналыг олгоно. Үүнд:

- 1/. Тэргүүн байр аймгийн ИТХ-ын өргөмжлөл, 500000 хүртэл төгрөг
- 2/. Дэд байр аймгийн ИТХ-ын өргөмжлөл, 300000 хүртэл төгрөг
- 3/. Гутгаар байр аймгийн ИТХ-ын өргөмжлөл, 200000 хүртэл төгрөг

6.2 Тус ажил үнэлэх журмаар Багийн ИНХ ажлыг дүгнэх ба жил бүр 3 хүртэл багийн ИНХ-ын ажлыг шалгаруулан шагнана. Үүнд

- 1/ Тэргүүн байр аймгийн ИТХ-ын өргөмжлөл, 200000 хүртэл төгрөг
- 2/. Дэд байр аймгийн ИТХ-ын өргөмжлөл, 150000 хүртэл төгрөг
- 3/ Гутгаар байр аймгийн ИТХ-ын өргөмжлөл, 100000 хүртэл төгрөг

6.3 Сум бүр тус ажлын /хамаарах/ үнэлгээний үзүүлэлтээр 1 багийн ИНХ-ын тайлангийн жилийн үйл ажиллагааг үнэлэн тодорхойлолтыг гаргаж Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцсэн материалын хамт жил бүрийн 1 дүгээр сарын 20-ны дотор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын албанд ирүүлнэ.

6.4 Ажлын үнэлгээгээр шалгарч байр эзэлсэн сумдын ИТХ-ын шагналын 30.0 хувийг сумын ИТХ-ын дарга, нарийн бичгийн даргад, багийн ИНХ-ын шагналын 20.0 хувийг багийн ИНХ-ын даргад урамшууллын хэлбэрээр олгоно.

6.5 Үнэлгээгээр үйл ажиллагаа нь хангалтгүй буюу 60.0 хувиас доош оноо авсан, онооны дүнгийн жагсаалтаар сүүлийн байр эзэлсэн сумын ИТХ-д ажил сайжруулах тухай албан шаардлага, зөвлөмж хүргүүлнэ.

...oOo...